

Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөрийн ХШҮ-ний тайлан

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО							
1	3.3.6. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	3. Экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ	2021 - 2024		Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 50-аас доошгүй ААН-д хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалтын дэмжлэг үзүүлнэ	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Бичил бизнес эрхлэгчдэд зориулан хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах ажлыг орон даяар нэгэн зэрэг зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд 500,0 сая төгрөгийн санхүүжилтэд багтаан ХХААХҮ-ийн Сайдын баталсан журмын дагуу 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 07 дугаар сарын 06-ны өдрүүдэд аж ахуйн нэгжийн төслийг ЖДҮ-ийн газрын цахимаар хүлээн авч ил тод нээлттэй нээлттэй зарласан бөгөөд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд төслөө ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн төслийг сонгон шалгаруулах аймгийн дэд хорооны хурлыг 2022 оны 10 сарын 18-нд зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд цахимаар 3 сумын 11 аж ахуйн нэгжийн 1.899.171 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл хүссэн төслийг хүлээн авсан ба дээрх төслүүдэд журмын дагуу 4 шатны үнэлгээ явагдаж 2 аж ахуйн нэгж байгууллагын 175 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл хүссэн төслүүд нь журмын шаардлага хангасан бөгөөд 175 сая төгрөгийн санхүүжилтийг баталж аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулж ЖДҮ-ийн газарт хүргүүлээ. Германы Олон Улсын Хамтын ажиллагааны Нийгэмлэгийн (GIZ) “Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих (PROGRES) төсөл” нь Шинэ Ховд	100

						Бизнес хөгжлийн төвтэй хамтран “Залуу бизнес”, “Ногоон ажлын байр, ногоон эдийн засаг”, “Бүтээмжийг дээшлүүлэх дэд хөтөлбөр”, “Брэндийн хөтөлбөр”, “Эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах” зэрэг 5 хөтөлбөр хэрэгжихэд 42 хүн сонгон шалгаруулалтанд оролцсоноос 26 хүнд 140,000,000 төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэгийг төслийн зүгээс үзүүлсэн ба 2 удаагийн Эвент арга хэмжээнд 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Мөн Жаргалант сумын хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдах хүсэлтэй иргэдийн төслийг 10 дугаар сарын 21-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл 30 хоногийн дотор хүлээн авч байна.	
2	3.3.9. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.	2. Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ.	2021 - 2024		Ээрэх, нэхэх, сүлжих хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлснээр 100 орчим ажлын байр бий болсон байна.	Боловсруулах үйлдвэрүүдийг чанар, стандартын шаардлага хангасан түүхий эдээр хангах, малчдын орлого, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор Дарви суманд Баялаг сутайн хөгжил хоршоог түшиглэн 5000 ширхэг арьс нэхий боловсруулах жижиг оврын үйлдвэрийг, Зэрэг сумын Алтан тээлийн баян өгөөж хоршоо өөрийн хөрөнгө оруулалтын 20.0 сая төгрөгөөр, 70 м2 түүхий эдийн склад тус тус барьж ашиглалтад орууллаа. Иргэдийн бизнес эрхлэх боломжийг хангах зорилгоор жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихээр “Үйлдвэрлэгч Ховд” дэд хөтөлбөрийг баталсан бөгөөд дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 100 сая төгрөг батлагдаж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Улсын төсвийн 55 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай Чандмань сум дахь арьс шир элдэх, боловсруулах жижиг оврын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тендер зарлагдаж “Дунд голын рашаан” ХХК шалгарч, үйлдвэрийг ашиглалтад оруулаад байна. Хоршоог хөгжүүлэх сангаас Булган сумын иргэн Баянмөнхийн арьс боловсруулах төсөлд 10,0 сая, Шинэ хөдөө” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 62,825,880 төгрөгийн үнэ бүхий “Адууны махан бүтээгдэхүүн каз	90

						боловсруулах” тоног төхөөрөмжийг Жаргалант сумын Еркежан нөхөрлөлд олголоо.	
3	3.3.10. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	2. Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ	2021 - 2024		ҮТП-ийн дэд бүтцийн ажлын явц 90 хувь, үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын явц 30 хувь	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/ 2022-2023 онд 19,250 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээс энэ жил 1,16 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд бүтээн байгуулалтын ажлыг 50 хувьд хүргэх юм. Энэхүү ажлын хүрээнд орон нутгийн зүгээс дэд бүтцийн ажлын даалгаврыг боловсруулан батлуулж ХХААХҮЯ-нд хүргүүлсэн ба тус ажлыг 6 багц болгон зарлаж, гүйцэтгэгч шалгаран гэрээ байгуулан ажлаа эхлээд байна. Багц 1: Авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, инженерийн шугам сүлжээний төлөвлөлт, үерийн усны сувагчлалын зураг төсөв боловсруулах, барих ажлыг “Батдайчин” ХХК-н шалгарсан гэрээ байгуулсан зураг төсөв зохиох шатандаа, Багц 2: Саарал ус зайлуулах, Усан хангамж, Ариутгах татуургын цуглуулах гол шугам сүлжээний зураг төсөв боловсруулах, барих ажилд “Воком констракшн ХХК”-н шалгаран гэрээ байгуулсан зураг төсөв зохиох шатандаа. Багц 3: Цахилгаан хангамжийн дэд станц, шугам сүлжээний зураг төсөв боловсруулах, барих “Эм Ай Эс Эс” ХХК-н шалгаран гэрээ байгуулсан зураг төсөв зохиох шатандаа. Багц 4: Мэдээлэл холбооны сүлжээний зураг төсөв боловсруулах, барих “Мон Кабель”ХХК-н шалгаран гэрээ байгуулсан зураг төсөв зохиох шатандаа. Багц 5: Арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн зураг төсөв боловсруулах, “Жаргалант луу”ХХК-н шалгаран гэрээ байгуулсан зураг төсөв зохиох шатандаа. Багц 6: Уурын дулааны дэд станц, шугам сүлжээний зураг төсөв боловсруулах, барих Жаргалант луу”ХХК-н шалгаран гэрээ байгуулсан зураг төсөв зохиох шатандаа. Ажлын гүйцэтгэл 10% он дамжин хэрэгжтх бөгөөд 2022 оны төлөвлөсөн ажил 90 хувьтай хэрэгжиж байна. ҮТП-ийн дэд бүтэц хийгдсэний дараа үйлдвэрүүд баригдаж эхлэх бөгөөд паркад баригдах үйлдвэрүүдийн төслүүдийг хүлээн авч байна.	90

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны жилийн эцсийн биелэлт-Ховд

4	3.7.4. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууриныг тодорхойлж, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээнд холбоно.	5. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулна.	2020 - 2024		18 сум	Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох төсөлтэй хамтран ажиллаж Мянгад, Зэрэг, Эрдэнэбүрэн сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг “Лак ланд” ХХК-аар гүйцэтгүүлж байна. Төлөвлөгөө боловсруулах ажил суурин судалгааны шатандаа явж байна. Мөн дээрх төслийн санхүүжилтээр Алтай, Үенч, Дуут, Жаргалант, Булган, Мөнххайрхан, Манхан, Дөргөн сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг “Тэгш хэм групп” ХХК тус тус гүйцэтгэж байна. Орон нутгийн төсөвт дээрх ажлыг гүйцэтгүүлэх зардлыг тусгуулахаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Газар зохион байгуулалт, хот төлөвлөлт, хөгжлийн хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр санал хүргүүллээ.	70
5	3.7.9. Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлнэ.	8. Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулна.	2020 - 2024		Түрээсийн орон сууцны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Хувийн хэвшлийн хөрөнгөөр Жаргалант сумын Магсаржав багт гэр бүлийн хэрэгцээний газрыг худалдан авч, “Пламинг деволопмент” ХХК, “Сац гурван хайрхан” ХХК, “Тэгш стандарт” ХХК-нууд 5 айлын газарт 90 айлын орон сууц, “Эрдэний шим” ХХК 2 айлын газарт 45 айлын орон сууц, “Бат арга билэг” ХХК 2 айлын газарт 45 айлын орон сууцны барилга барьж байна. Мөн Жаргалант сумын Бугат багт “Ховд баганат” ХХК 1 айлын газарт 28 айлын орон сууц, “Баруун жонон” ХХК 1 айлын газарт 28 айлын орон сууц, “Шүрэн баян уул” ХХК 2 айлын газарт 75 айлын орон сууц, “Марч констракшн” ХХК 2 айлын газарт 138 айлын орон сууц, “Ховдын хаш өргөө” ХХК 2 айлын газарт 72 айлын орон сууц, “Эрхэт модун” ХХК 2 айлын газарт 180 айлын орон сууц, “Залай Алтай” ХХК 2 айлын газарт 56 айлын орон сууц, Цамбагарав багт 8 айлын газарт 240 айлын орон сууцны хотхон хорооллын барилга угсралтын ажил эхлүүлж, зохих дүрэм журам, стандартын дагуу ажлаа	90

					гүйцэтгэж байна. Ховд аймагт нийтдээ гэр хорооллын 6 байршилд 29 айлын 35229 м2 хашааны газарт 1031 айлын орон сууцны хотхон, хороолол баригдах ажил хийгдэж байна. Дээрх орон сууцны барилгуудыг инженерийн шугам сүлжээнд холбогдох ажилд аймаг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020-2022 онд 2 дулаан дамжуулах төвийн барилгыг ашиглалтад оруулж, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар “дулаан дамжуулах төв ДДТ-13” байгуулах ажлыг “Очир буян өргөө” ХХК хийж гүйцэтгээд хүлээлгэж өглөө. Аймгийн хэмжээнд Төрийн орон сууцны корпорацийн 120 айлын орон сууцнаас түрээсээр авсан иргэдийн 60% төлөлтөө хийж хувийн өмчийн хэлбэрт шилжүүлээд байна. Аймгийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын байдлаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 229 айлын 9 орон сууцны барилга ашиглалтад орсон байна.	
6	3.7.12. Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	4. Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2021 - 2024	Барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	Жаргалант сумын үерийн хамгаалалтын 1.4 км далан сэргээх, 3.7 км үерийн шуудуунд цемент бетон чигжээстэй чулуун бэхэлгээ хийх, харуулын 4х6 м харьцаатай байр барих зэрэг ажлын тендерт “Урбан девелопмент консалтинг групп” ХХК шалгарч, 2021, 2022 онд гүйцэтгэхээр байсан боловч 2,1 км шороон даланг сэргээх, 4х6 хэмжээтэй харуулын байрны барилгын ажлыг гүйцэтгэн эхний санхүүжилтээр 100,0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэж, тус ажлыг хүлээн авсан байна. Тус ажил нь нийт 400,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай бөгөөд үлдэгдэл ажлын хөрөнгө оруулалтыг 2023 онд оруулахаар төсөвт тусгасан тул гүйцэтгэгчийн ирүүлсэн хүсэлтийн дагуу ажил гүйцэтгэх гэрээг цуцлаад байна. Мөн “Хаан ус тэнгис” ХХК-ийн хийсэн Ховд хотын үерийн хамгаалалтын байгууламжийн ажлын 16,505,968,917 төгрөгийн зураг төсөв хийгдэж хүлээн авлаа.	70

7	3.7.13. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.	3. Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.	2020 - 2024		Цементийн үйлдвэрийн туршилт тохируулгыг хийж ашиглалтад оруулна.	Буянт сумын нутаг дахь “Ховд эко цементийн үйлдвэр”-ийг барьж ашиглалтанд оруулахаар барилгын ажил 2020 онд эхэлж, 2022 онд ашиглалтад оруулахаар ажиллаж барилга угсралт, тоног төхөөрөмж суурилуулах ажил дуусч эхний туршилтын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх ажлыг эхлүүлээ. Баруун бүсийг хямд, чанартай цементээр бүрэн хангах Ховд эко цементийн үйлдвэрийн маань “Чулуунцар үйлдвэрлэх хэсэг” ашиглалтад орж, зуухаа галласан бөгөөд арваннэгдүгээр сарын 3-ны өдөр эхний ээлжийн цементээ үйлдвэрлэж эхэллээ. Баруун таван аймгийг Улаанбаатар хотын үнээр, чанартай цементээр бүрэн хангах боломж ийнхүү нээгдлээ. Төрийн бодлогод туссан хөгжлийн бүтээн байгуулалт болох үйлдвэр маань ашиглалтад орсноор: Барилгын талх-хямд чанартай цементээр баруун бүсээ хангана. Барилгын материалын үйлдвэрлэл хөгжих үндэс тавигдана. Жилдээ 300 мянган тонн цемент үйлдвэрлэж баруун бүсийн хэрэгцээг хангана. Барилга, орон сууц бүтээн байгуулалтын өртөг зардал буурна. Шууд 320 гаруй, шууд бусаар 3000 хүний байнгын ажлын байр бий болно. Утааг бууруулж янданг цөөлнө. Баруун бүс нутгийн хөгжлийн зүтгүүр болох юм.	100
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
8	4.3.11. Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын	2. Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс амжиж анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог	2021 - 2024		Өвөрхангайн Төгрөг, Өмнөговийн Мандал-Овоо, Дорноговийн Мандах,	УЦУОШ-ний төвөөс Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу байгаль цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл ажиглагдах нөхцөл бүрдсэн үед гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ гаргадаг ба тухайн үзэгдлийн хязгаарлах утганд хүрч ажиглагдахгүй тохиолдолд анхааруулах мэдээг гаргаж	70

	байгууллагын техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлэх, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулна. Цаг агаарын аюул, гамшгийн үед үзэгдэлд суурилсан амжиж анхааруулах орон нутгийн мэдээг үүсгэж, аймаг, сумын төвөөс малчдад хүргэн түгээж, бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх зорилгоор орон нутгийн мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборуудыг эрсдэл өндөртэй бүсүүдэд байгуулна.	дэмжин хөгжүүлэх говь, хээрийн бүсэд аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 17 цогцолбор байгуулна.			Сүхбаатарын Баруун-Урт суманд нийт 4 цогцолбор байгуулна.	орон нутгийн удирдлага, ард иргэдэд Багц мэссэж үйлчилгээ болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл /телевиз, радио/, олон нийтийн цахим сүлжээ /Ховд Ус цаг уур орчны шинжилгээний төв фэйсбүүк пэйж хуудас, alarm.tsag-agaar.gov.mn, khovd.tsag-agaar.gov.mn вэб сайт/ ашиглан хүргэж байна. 2022 оны эхний 10 сарын байдлаар анхааруулга мэдээг 30 удаа, сэрэмжлүүлэг мэдээг хүчтэй салхиар 4 удаа, урьдчилан сэргийлэх мэдээг хүчтэй салхиар 1 удаа, цочир хүйтрэлтээр 6 удаа гаргаж Багц мэссэж үйлчилгээг ашиглан аймгийн болон сум, орон нутгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, орлогч дарга, багийн дарга, багийн идэвхтэн өрх, ИТХ-ын Нарийн бичгийн дарга, төрийн байгууллагын дарга нар, аймгийн Онцгой комиссын гишүүд, сумын хэсгийн төлөөлөгчид зэрэг 1200 гаруй албан тушаалтанд хүргэсэн байна. Мөн харъяа цаг уурын 9 өртөө, 7 харуулын техникч нараар дамжуулан албан бичиг болон сумын мэдээллийн нэгдсэн сайтуудад цахим хэлбэрээр байршуулан сум орон нутгийн иргэдэд мэдээллээ.	
9	4.6.3. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.	1. Аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавина.	2020 - 2024		Сум, дүүргийн орон нутгийн хамгаалалтын 340 төлөвлөгөөг хянаж, тодотгол хийгдэнэ.	Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг болон Батлан хамгаалахын багц хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Дайчилгааны тухай хууль, Дайны байдлын тухай хууль, Онц байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 86 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2018 оны н/25, мн/26 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2019 оны мн/01 тоот захирамж, 2020 оны мн/01-17 тоот удирдамжуудыг тус тус үндэслэн аймгийн нийт сумдын Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 оны 07 дугаар сард аймгийн нийт сумдын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилт, бие бүрэлдэхүүн техникийн томилгоожуулалтад тодотгол хийхээр төлөвлөж, 10 дугаар сард бүх сумдад зохион байгуулсан болно. Тодотголоор шалган туслах ажил гүйцэтгэж, орон нутгийн хамгаалалтын нөөцөд	100

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны жилийн эцсийн биелэлт-Ховд

					бүртгэгдсэн иргэд, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшлийн галт зэвсэг, техник, материал хэрэгслийг томилгоот нэгжүүдэд хуваарилан даалгаваржуулсан байдлыг шалгаж нөөц бүрдүүлэх талаар сум орон нутгийн төсөвт төсөв тусгагдсан эсэхийг шалгаж үнэлсэн байна.	
10	2. Орон нутгийн хамгаалалтын сургалтын тогтолцоог бүрдүүлэх, томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангана.	2020 - 2024		Орон нутгийн цэрэг, томилгоот нэгжийн 22 сургалт зохион байгуулагдана.	2022 оны 07 дугаар сард нийт сумдаар шалган туслах ажил буюу “Орон нутгийн хамгаалалтын удирдах бүрэлдэхүүнд мэдлэг, дадлага олгох сургалт”-ыг, томилгоот нэгжийн бие бүрэлдэхүүнд гүйцэтгэх үүрэгт нь чиглэсэн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Монгол улс болон Оросын холбооны улсын зэвсэгт хүчний хооронд зохион байгуулсан “Сэлэнгэ-2022” хамтарсан хээрийн сургууль болсонтой уялдан энэхүү арга хэмжээг хойшлуулан, 10 дугаар сард цэрэг татлагын үеэр зохион байгуулсан болно. Мөн Цэргийн штабын сургалтын төлөвлөгөөний дагуу явагдах орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд Дуут сумын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй онол болон дадлагын хэлбэрээр тухайн сумын нутагт зохион байгууллаа. Томилгоот нэгжийн сургалтад Дуут сумын удирдлага болон цагдаагийн алба хаагчид дэмжлэг үзүүлж оролцсон бөгөөд сургалтаар томилгоот нэгжийн бүрэлдэхүүнд гүйцэтгэх үүрэгт нь чиглэсэн сургалтыг дадлага зонхилсон хэлбэрээр зохион байгуулснаар томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг дээшлүүллээ.	100
11	3. Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв	2020 - 2024		Нэгдсэн төлөвлөгөө бүрэн хийгдэж, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн	Аймгийн “Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө”, “Зэвсэгт хүчний анги, салбарыг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”, “Орон нутгийн цэргийг байгуулах, бэлтгэлийг хангах төлөвлөгөө”-г тус тус зааврын дагуу боловсруулж ЗХЖШ-ын холбогдох албан	100

		байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөө, даалгаврыг шинэчилнэ.			дайчилгааны даалгаврын төсөл боловсруулагдсан байна.	тушаалнуудаар хянуулан 2021 онд батлуулсан болно. Сумдад тогтоосон дайчилгааны даалгаврын дагуу сумдаас оногдуулан бүртгэгдсэн цэргийн бэлтгэл үүрэгтэн, техникийн тодотголыг 2022 оны 05 дугаар сард Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 305 дугаар салбартай оногдуулан, бүртгэгдсэн цэргийн бэлтгэл үүрэгтэн, авто техникийг тодотгосон байна. Батлан хамгаалах яамнаас Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан аймгийн Улсын дайчилгаа хариуцсан албан тушаалтан төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаас холбогдох судалгаа авч тайланг маягтын дагуу гаргаж 2021 оны 10 дугаар сард БХЯ-нд хүргүүлсэн болно.	
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
12	5.1.4. Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	1. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.	2020 - 2024		Улаанбаатар хот болон төв суурин газрын 2000-аас доошгүй жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлсэн байна.	Ховд аймаг дахь ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгүүдэд 2022 оны байдлаар зориулалтын бус нийт 42 нүхэн жорлон ашиглаж байгаа судалгаа гарсан байна. 2022 оны байдлаар "Шинэ Ховд Жаргалант" ТҮК ОНӨААТГ нь Буянт голын зуслангийн айл өрхүүдэд 11 ширхэг эко соруулдаг жорлон болон зөөврийн татан зайлуулдаг 16 ширхэг функер байршуулж, хөрсний бохирдлоос сэргийлэн ажилласан бөгөөд Буянт голын зуслангийн айл өрхүүдэд зориулалтын бус 90 орчим нүхэн жорлонг ашиглаж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 11 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор дээрх жорлонгуудыг буулгалаа. Ялангуяа "Усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ыг хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байна. 2022 онд орон нутгийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 10	90

						ширхэг сайжруулсан эко жорлонг хийхээр Шим ус ОНӨҮГ-тай гэрээ байгуулан, хийж гүйцэтгэж байна. Жил бүр Буянт голын Жаргалант сумаар дайран өнгөрөх ай сав дагуу зусланд 1000-1300 гаруй айл өрх нэг дор гарч байгаа нь Буянт голын даац хэтэрч зүлэг ширгэн дээгүүр авто машинтай зорчидгоос үүдэн хөрс талхлагдаж их хэмжээний хог хаягдал үүсч гол ус бохирдож байгаагаас гадна иргэд дур мэдэн нүхэн жорлон бий болгожээ. Зарим айл өрхүүд зусланд гарахдаа өөрсдөө 00 байгуулсан бөгөөд Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа, Жаргалант Сум ЗДТГ, Шинэ Ховд Жаргалант ТҮК хамтран 10 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд 88 нүхэн жорлонг буулгаж ариутгал хийж дарж буллаа.	
13	5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.	1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.	2020 - 2024		Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.	Аймгийн хэмжээнд хууль бус ашигт малтмал олборлолтын улмаас эвдрэлд орж орхигдсон Алтай сумын нутаг Ендэрт ус хэмээх газарт “Ариун уул ар булаг” нөхөрлөл 3 га, Тамт хэмээх газарт “Баян алтайн бураат” нөхөрлөл 1.5 га талбайд орон нутгийн хөрөнгөөр, Өвөр булаг хэмээх газарт “Талст молор” ХХК 2 га, Майхан хар хэмээх газарт 5 га, Хөндийн ам хэмээх газарт 3 га, Үенч сумын нутагт автозам дагуу эвдрэлд орсон 10 га талбайд “МоЭнКо” ХХК-иуд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлтийг хийж нийт 24.5 га талбайд 49.050.030 төгрөг зарцууллаа.	100
14	5.1.11. "Хөх морь" төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан	2. Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас,	2020 - 2024		Хөв цөөрмийг 3-аас доошгүй газарт шинээр байгуулах, 120-аас доошгүй булаг шандны эхийг хашиж хамгаалсан байна.	2022 онд Улаан богочийн рашаан, Дарви сумын Мөрөн багийн цагаан давааны булгийг тохижуулж хамгаалатанд авлаа. Мөн аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар, Үенч Бодонч Булган голын сав газрын захиргаа, сумдын Байгаль орчны алба, ГИДЦГ-ын ХЗ-тай хамтран, Усны нөөцийг хамгаалах, хомсдож бохирдохоос сэргийлэх зорилгоор Алтай сумын Алтангадас багийн нутаг болох Шангийн булаг, Бодонч	100

	төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.	мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулна.				багийн Хөндлөнгийн Шаварын булаг, Барлаг багийн Шил усны булаг, Элсэн ус, Сухайтын усны булаг, Булган сумын Байтаг багийн нутагт орших Бүдүүний усны булаг, Баян-Өлгий аймгийн Булган сумын Улаанхус багийн зуслангийн бүс нутаг болох Хөшөөн нуурууны булаг, Үенч сумын Улиаст багийн Цагаан эргийн рашааны эх, Хулстайн булаг нийт 9 булгийн эхийг томоохон ус ашиглагч МоЭнКо ХХК, Талст Молор ХХК, ОУ Тахь групп болон орон нутгийн санхүүжилтээр хашиж хамгаалсан байна. Монгол оны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” /адапт/ төслийн захиалгаар Престиж инженеринг ХХК-ийн захирал Н.Ганзориг, мэргэжилтэн Б.Цэрэндаваа, Монгол улсын усны зөвлөх инженер Доктор Даваа нар Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргаатай хамтран Булган сумын Баянгол багийн Цахир үзүүр, Үенч сумын Улиастын ам, Байтаг багийн Хужирт, Бүдүүн харгайтын голын адагт хөв, цөөрөм байгуулах боломжтой голуудын усны өнгөрөлтөд физик, химийн хэмжилтүүд хийж судалгаа гаргасан байна.	
ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
15	6.2.5. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.	1. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг	2021 - 2024		Хэрэгжилтийг хангана.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд байнгын үйл ажиллагаа явуулдаг, хуулийн этгээдийн ерөнхий захиргаа нь тухайн орон нутагт бүртгэлтэй, орон нутгийн татварын албатай харьцдаг, ажлын байр бий болгож /нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажсан/ байгаа энэ хуулийн 5.3.1-д заасан албан татвар төлөгчийн тухайн аймаг, сумын нутаг дэвсгэр дээр явуулсан үйл ажиллагаанаас олсон энэ хуулийн 7.4.1-д заасан албан татвар ногдох орлогод ногдох албан татварыг аймаг,	90

		бодлогоор дэмжинэ.				сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар хөнгөлөх татварын шаталсан тогтолцооны талаар сургалт хийлээ. Энэ сургалт нь орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг дэмжих сурталчилгаа болж байна. 2022 оны байдлаар тус аймагт ХХК 208, хоршоо 34, нөхөрлөл 19, төрийн бус байгууллага 14, шашны байгууллага 1, салбар 2, сан 1, ҮЭ байгууллага 3, нийт 283 аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар ААНОАТ-ын тухай хуулийн 22.5.1 дэх заалт /зайн хөнгөлөлт/-аар 15 аж ахуйн нэгж 290,917.9 мянган төгрөг, 22.1 дэх заалт /борлуулалтын орлого 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар тайлагнасан/-аар 19 аж ахуйн нэгж 48,830.4 мянган төгрөгийн хөнгөлөлтөнд хамрагдаж, 28.4 заалт /татварын буцаан олголт/-аар 8 аж ахуйн нэгж 8,053.9 мянган төгрөгийн илүү төлсөн татвараа буцаан авсан байна. Мөн ХХОАТ-ын тайлангаар 1194 иргэн 728584.6 мянган төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн буцаан олголт авсан байна. Энэ нь тухайн алслагдсан орон нутат аж ахуйн нэгжүүд салбараа байгуулах, үйл ажиллагаагаа эрхлэн явуулахад түлхэц болж байна.	
16	6.2.8. Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	1. Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг бүрт гэр хорооллын 600-аас доошгүй өрхийг	2020 - 2024		Гэр хорооллын 3000 өрх инженерийн сүлжээнд холбогдсон байна.	Барилга, хот байгуулалтын сайдын багцад Гэр хорооллын цэвэр бохир усны шугам, сүлжээ /Ховд, Жаргалант сум, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/-ний 9,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Ховдын өргөө” ХХК хийж гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд 2022 онд цэвэр усны 12485 м, бохир усны 5875м шугамын ажил хийгдсэн ба 2020-2021 онд гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний угсралтын ажил хэрэгжсэн Тахилт, Бичигт, Баатархайрхан багийн 400 айл өрхийг “Хашаандаа сайхан амьдаръя” төслийн хүрээнд цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох ажлыг 731 сая төгрөгөөр “Шим-Ус” ОНӨААТҮГ хэрэгжүүлэн ажиллаж, одоогоор 80	100

		инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцлийг сайжруулна.				гаруй айл өрхөд бүрэн холболт хийсэн байна. 2022 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар гэр хорооллын 120 айлыг цэвэр бохирын шугам сүлжээнд холбоод байгаа ба ажил хэвийн үргэлжлэн явагдаж байна.	
17	6.2.10. Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.	1. Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.	2021 - 2024			Байгальд ээлтэй нөөцийн хэмнэлттэй үр ашигтай үйлдвэрлэлийг дэмжих замаар Ховд аймгийн Жаргалант суманд хуванцар боловсруулах жижиг үйлдвэр барих 200,000 төгрөг /хоёр зуун сая/-ний тендерийг 2022 онд аймгийн Засаг даргын Тамгын газраас зарласан байна. Ховд аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн “Хог хаягдлын талаар авч хэрэгжүүлэх” 03 тоот албан даалгавар, 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/600 дугаар захирамжаар орон нутагтаа “Хог хаягдлын журмуудыг боловсруулах” ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргаас санаачлан хог шатаах зуухны үйлвэрүүдийн төслийг боловсруулан БОАЖЯ-нд хүргүүлэхээр бэлтгэл ажлуудыг хийж байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтын хүрээнд хог хаягдал дахин боловсруулах төсөл сонгон шалгаруулалт зарласан ба “Хоногт хас” ХХК-ны “Био бордооны үйлдвэр төсөл”, Өв аз жаргалын булаг ХХК-ны “Хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгаж, нэг цэгт төвлөрүүлэн боловсруулах төсөл”, Талст чиглэл ХХК-ны “Эрчим хүчний хаягдал үнсийг дахин ашиглах төсөл”-ийг тус тус дэмжиж жилийн 3 хувийн хүүтэй зээлийг олгосон шийдвэрийг гаргалаа. Хоногт хас ХХК-ны “Био бордооны үйлдвэр төсөл” нь малын гаралтай хаягдал түүхий эд болох арьс, шир, яс, эвэр, туурай, сэвс болон цаас ашиглан био бордоо үйлдвэрлэн баруун бүс төдийгүй бусад аймгуудад нийлүүлэх боломж бүрдэх ба үүнийг Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэхэд ашиглахад үр дүнтэй гэж үзэж байна. “Талст чиглэл” ХХК-ны “Эрчим	90

						хүчний хаягдал үнсийг дахин ашиглах төсөл” нь аймгийн төвлөрсөн дулааны станцаас гарч буй хаягдал үнсийг ашиглан дүүргэлтийн блок үйлдвэрлэж иргэд, аж ахуйн нэгжүүдэд худалдан борлуулж байна. Мөн Технологи бридж ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулсан бөгөөд үүний хүрээнд хуванцар сав хүлээн авч, төлбөр олгох 2 ширхэг автомат машиныг худалдан аваад байна.	
18	6.2.12. Сум, орон нутагт ажиллахаар анх удаа очиж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар түр хангах цогц арга хэмжээг төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлнэ.	1. Аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж, амьдарч байгаа эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх хүрээнд албаны орон сууцаар хангах ажлыг зохион байгуулна.	2021 - 2024		Албаны орон сууцаар хангагдсан байна.	Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдаж, түүнийг дагаж гарсан дүрэм, журмын хүрээнд 17 сумын ЗДТГ, ЗД-ын эрхлэх асуудлын хүрээний 23 агентлаг “Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрөө шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Шүүхийн шинжилгээний алба Булган суманд 79,0 сая төгрөгөөр 2 албан хаагчдаа ажлын байр, орон сууц барьж ашиглалтанд орсон. Прокурорын газар 56,0 сая төгрөгөөр 2 албан хаагч, Гадаадын иргэн харьяатын Баруун бүсийн газар 50,0 сая төгрөгөөр Булган суманд 3 албан хаагч, Баруун бүсийн эмчилгээний төвийн Булган сумын нэгдсэн эмнэлэг “Эмч эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор сууршилтай ажиллуулах үүднээс хөнгөлттэй нөхцөлтэй байр, орон сууцаар хангах” арга хэмжээний хүрээнд газрын асуудлыг шийдвэрлэн Ховдын Жаргалант луу, Ховдын өргөө ХХК-тай хамтран 2 тэрбум 400 сая төгрөгний санхүүжилтээр 45 айлын орон сууцыг бариулж байна. 2022 оны байдлаар Эрүүл мэндийн салбарын ажилчдаас ипотекийн болон түрээсийн орон сууцны зээлд хамрагдах хүсэлтэй 190 эмч мэргэжилтэн байна. Аймгийн Засаг дарга нь эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнуудын орон сууцны хэрэгцээнд зориулан 400 кв газрын асуудлыг шийдвэрлэж батламж олголоо. Боловсролын салбарын чиглэлээр нийгмийн хамгаалал шаардлагатай албан хаагч ажилчиддаа салбар байгууллагуудын дотоод журмын хүрээнд дэмжлэг	70

						үзүүлэн ажиллаж байна. Засгийн газрын 2009 оны 246 дугаар тогтоолоор тус аймагт алслагдсанд тооцогдох сумдад Мөст, Алтай, Цэцэг сумд орсон ба эдгээр сумдад амьдарч байгаа хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын алба хаагчид байхгүй болно	
19	6.2.13. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	1. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	2021 - 2024		Ажлын байр нэмэгдсэн байна.	Малын гаралтай түүхий эдийн бэлтгэлийн төвийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Мөст суманд барих ажлын тендерт Наран тулгуур ХХК шалгарч, барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байна. Тус төв ашиглалтад орсноор 20 гаруй хүний ажлын байр бий болох бөгөөд барилгын ажлын гүйцэтгэл 90 гаруй хувьтай энэ ондоо багтаан ашиглалтад орох юм. Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих Засгийн газрын 2012 оны 171 дүгээр тогтоолд “Цементийн үйлдвэрлэлийг хүн амын суурьшил, барилгажилтын хэтийн төлөв, зах зээлийн эрэлт хэрэгцээ, тээвэрлэлтийн нөхцөлтэй уялдуулан төв, баруун, зүүн, говийн бүсэд бүсчлэн байгуулах” тухай заасан байдаг. Мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан болон 2015 оны 335 дугаар тогтоолд “Баруун бүсэд барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор Ховд аймгийн Буянт сумын нутагт “Вестерн Холд” ХХК-ийн 250 мянган тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг барьж ашиглалтад оруулахыг дэмжих тухай” тус тус заасны дагуу Буянт сумын нутаг дахь “Ховд эко цементийн үйлдвэр”-ийг барьж ашиглалтанд оруулахаар барилгын ажил 2020 онд эхэлж, 2022 онд ашиглалтад оруулахаар ажиллаж барилга угсралт, тоног төхөөрөмж суурилуулах ажил дуусч эхний туршилтын бүтээгдэхүүнийг 11 дүгээр сарын 3-ны өдрөөс үйлдвэрлэн гаргаж эхэллээ. Ийнхүү баруун таван аймгийг Улаанбаатар хотын үнээр,	100

						чанартай цементээр бүрэн хангах боломж ийнхүү нээгдлээ. Төрийн бодлогод туссан хөгжлийн бүтээн байгуулалт болох үйлдвэр маань ашиглалтад орсноор: Барилгын талх-хямд чанартай цементээр баруун бүсээ хангана. Барилгын материалын үйлдвэрлэл хөгжих үндэс тавигдана. Жилдээ 300 мянган тонн цемент үйлдвэрлэж баруун бүсийн хэрэгцээг хангана. Барилга, орон сууц бүтээн байгуулалтын өртөг зардал буурна. Шууд 320 гаруй, шууд бусаар 3000 хүний байнгын ажлын байр бий болно. Утааг бууруулж янданг цөөлнө. Баруун бүс нутгийн хөгжлийн зүтгүүр болох юм.	
20	6.2.14.. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.	2. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.	2021 - 2024		Дэд бүтцийг бий болгоно.	Гарааны бизнесийг хөгжүүлэх, инновацийн технологийг нэвтрүүлэх, гарааны бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн (GIZ) “Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих (PROGRES) төсөл” нь Шинэ Ховд Бизнес хөгжлийн төвтэй хамтарч, 5 хөтөлбөр хэрэгжүүлж, 42 хүн сонгон шалгаруулалтанд оролцсоноос 26 хүнд 140,000,000 төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэгийг төслийн зүгээс үзүүллээ. Аймгийн Засаг даргын “МоЭнКо” ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэх, бараа бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэгч, хоршоологчдын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах зорилгоор “Хөдөлмөрч Ховдчууд” арга хэмжээг зохион байгуулсан ба орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 30 гаруй аж ахуйн нэгж, компанийн төлөөлөл оролцож, бараа бүтээгдэхүүнээрээ үзэсгэлэн гаргав.	90

					09 дүгээр сарын 25-28 ны өдрүүдэд "ЦАЙНЫ ЗАМ ӨВ СОЁЛЫН III НААДАМ"-ын хүрээнд "Ховдод үйлдвэрлэв соёлын бүтээлч үйлдвэрлэл"-ийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, нийт 120.0 сая төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт хийлээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтаар энэ жил 1,16 тэрбум төгрөг батлагдсан ба энэхүү ажлын хүрээнд орон нутгийн зүгээс дэд бүтцийн ажлын даалгаврыг боловсруулан батлуулж ХХААХҮЯ-нд хүргүүлэв. Тус 6 багц ажлын гүйцэтгэгч шалгаран гэрээ байгуулан ажлаа эхэллээ. 2022 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хөшөөтийн уурхайг, Улсын чанартай авто замтай холбох замын зөвлөх үйлчилгээний тендер зарласан бөгөөд "Аварга зам "ХХК ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Ховд аймгийн хөдөөгийн 11 сум хатуу хучилттай авто замаар холбогдсон бөгөөд 2022 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хөшөөтийн уурхайг, Улсын чанартай авто замтай холбох замын зөвлөх үйлчилгээний тендер зарлаж, "Аварга зам "ХХК ажлыг гүйцэтгэн хүлээлгэж өгөв. Ховд аймгийн хөдөөгийн 11 сум хатуу хучилттай авто замаар холбогдсон ба 2022 онд АХБ-ны хөрөнгө оруулалтаар Ховд, Эрдэнэбүрэн сумын авто замыг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Чандмань сумдын төвийг хатуу хучилттай авто замтай болгохоор ажлыг эхлүүлэв. Дээрх ажлууд нь хөдөө, орон нутагт жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжихэд чиглэсэн томоохон арга хэмжээ болж байгаа бөгөөд бизнес эрхлэхэд таатай боломж бүрдэж байна. Жижиг, дунд үйлдвэрийн газрын даргын 2022 оны "Хоршоодын хөгжлийн үнэлгээг зохион байгуулах тухай" тушаалаар хөгжлийн үнэлгээ хийх удирдамж, аргачлалыг баталсны дагуу улсын хэмжээнд Хоршоодын хөгжлийн үнэлгээ зохион байгуулж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын 26-наас 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд хоршооны үнэлгээ
--	--	--	--	--	---

						хийгдэх юм. Энэхүү арга хэмжээ нь Хоршоодын хөгжлийн түвшинг тодорхойлж, цаашид хоршооны салбартаа баримтлах бодлого, арга хэмжээг төлөвлөх зорилготой юм.	
--	--	--	--	--	--	--	--

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Э.БОЛОРМАА

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН ДАРГА

Д.БЯМБАСҮРЭН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ц.ОЮУНЧИМЭГ